



Аймгийн Засаг даргын 2003 оны
172 дугаар захирамжийн хавсралт

БАЯНХОНГОР СУМЫН ТӨВИЙН ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ БҮХИЙ
ГАЗАРТ ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ХАРИЛЦААГ
ЗОХИЦУУЛАХ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Зорилго нь:Баянхонгор сумын төвийн инженерийн шугам сүлжээ бүхий газарт хотын хөгжлийн ерөнхий болон тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар эзэмшүүлэх, ашиглуулах, журмын 5.2 заасан зориулалтар газрыг олгоход дүгнэлт гаргах, мэргэжлийн комиссын ажиллах үйл ажиллагааг зохицуулахад журмын гол зорилго оршино.

2.Энэхүү журам нь аймгийн Засаг даргын 2003 оны 142 дугаар захирамжаар батлагдсан хил хязгаарт болон сумдад журмаар тогтоосон зориулалтаар газар эзэмших, ашиглах хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хамаарна.

3.Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах зарчмаар газрыг олгоход энэхүү журам хамаарахгүй.

Хоёр: Инженерийн шугам сүлжээ бүхий газарт зөвшөрөл олгох

Газрын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг дараахь шат дарааллаар гүйцэтгэнэ.

1.Инженерийн шугам сүлжээ бүхий газарт газар эзэмших, ашиглах хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд Засгийн газрын эрх бүхий байгууллагаас батлан гаргасан загварын дагуу аймгийн Засаг даргад хүсэлтээ гаргана.

2.Хүсэлт гаргасан газрын байршил нь аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж, ашиглуулахаар заагдсан бөгөөд бусдын эзэмшиж ашиглаж байгаа газартай ямар нэг хэмжээгээр давхцаагүй байна.

3.Аймгийн газрын албаны бүртгэл мэдэлэл хариуцсан мэргэжилтэн материал бүрдсэн эсэхэд хяналт тавин хүсэлтийг хүлээн авч он, сар, өдөр, минутаар тэмдэглэх бөгөөд энэ тухай тодорхойлолтыг хүсэлт гаргасан этгээдэд өгнө.

4.Газрын албаны мэргэжилтнүүд иргэн аж ахуйн нэгж байгууллагын өргөдлийг судалж, санал боловсруулан хуралд танилцуулах материал бэлтгэнэ. Хүсэлт, түүнд хавсрагсан бичиг шаардлага хангаагүй бол хүсэлт гаргагч этгээдэд татгалзсан хариуг мэдэгдлээр өгч бүртгэлээс хасна.

5.Газрын тухай хуулийн дагуу Баянхонгор сумын Хотын захирагч, Засаг даргаас санал авна.

6.Комисс нь газар эзэмших, ашиглах хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдлийг мэргэжлийн хүрээнд хэлэлцэн шийдвэрлэж дүгнэлт гаргана.

7.Тухайн газрыг комисс олгохоор зөвшөөрсөн тохиолдолд хүсэлт гаргагч этгээд уг газарт байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэнэ.

8.Комиссын болон байгаль орчны нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтийг үндэслэн аймгийн Засаг дарга газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай шийдвэр гаргана.

9..Аймгийн Засаг даргын шийдвэрийг үндэслэн албаны мэргэжилтнүүд газар эзэмшиж, ашигласны жилийн төлбөрийг тогтоож, газар эзэмших гэрээ байгуулж гэрчилгээ олгоно. Мэдээллийг мэдээллийн санд оруулж, зураг төслийн дагуу улаан шугам тавина.

Гурав.Мэргэжлийн комиссын бүтэц зохион байгуулалт

1.Засаг даргын дэргэдэх мэргэжлийн комисс нь комиссын дарга нарын бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.Мэргэжлийн комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг аймгийн Засаг дарга нар томилно.

Дөрөв.Мэргэжлийн комиссын ажиллах дэг.

- 1.Мэргэжлийн комиссын хурлыг шаардлагатай үед хийнэ.
- 2.Мэргэжлийн комисс 80 хувиас доошгүй эрцтэйгээр хуралдана.
- 3.Мэргэжлийн комиссын хурлаар хэлэлцээд шийдвэрлэсэн асуудлын биелэлтийг гаргаж нарийн бичгийн дарга дараагийн хуралд тайлагнана.
- 4.Комиссын гишүүд хүндэтгэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд мэргэжлийн зүгээс өөрийн оролцогчийг заавал байлцуулна.

Тав.Мэргэжлийн комисс, түүний эрхлэх ажил.

1.Комисс нь Баянхонгор сумын инженерийн шугам сүлжээ бүхий газар болон сумдын дор дурьдсан газарт газар эзэмших, ашиглах хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл болон газартай холбоотой зөрчил, маргааныг мэргэжлийн хүрээнд хэлэлцэн шийдвэрлэж дүгнэлт гаргана.

2.Баянхонгор аймгийн сумдад дор дурьдсан газрыг олгоход мэргэжлийн комиссын дүгнэлтийг зайлшгүй гаргуулсан байна. Шийдвэрлэвэл зохих газрын өргөдөл, хүсэлтийг сумдын газрын даамлаар дамжуулан хэлэлцэнэ. Үүнд:

- ШТСтанц
- Улсын чанартай томоохон барилга, байгууламж объект
- Улс, хот хоорондын зам, холбоо
- 35 кв-аас илүү цахилгаан дамжуулах шугам
- 50 ор хоногоос дээш хүчин чадалтай зочид буудал, амралт сувилал, аялал жуулчлалын газар
- Хог хаягдлын нэгдсэн цэг

3.Олгогдсон газруудын гэрээний биелэлтийг 2 жил тутамд хурлаар хэлэлцэж гэрээний биелэлт, хангалтгүй тохиолдолд гэрээг цуцлана.

4.Шаардлагатай объектуудад байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэсний дараа газар олгох асуудлыг шийдвэрлүүлнэ.

5.Шаардлагатай гэж үзвэл өргөдөл гаргагчаас нэмэлт материал, тодорхойлолт,

хөндлөнгийн санал, дүгнэлт гаргуулан авч болно.

6.Мэргэжлийн комисс нь албан бланктай байх бөгөөд Газрын албаны тэмдгийг хэрэглэж комиссын дарга нарын үсэг зурна.

7.Комисс нь холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажлынхаа үр дүнг аймгийн Засаг даргын өмнө бүрэн хариуцна.

8.Энэ журмыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Зургаа.Хориглох зүйл.

1.Аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд эзэмшүүлж, ашиглуулж болохоор зааснаас бусад газарт газар эзэмшүүлж, ашиглуулахыг

2.Хүсэлт гаргагч этгээд газрын харилцаанд урьд өмнө ямар нэг зөрчилтэй бөгөөд уг асуудал нь шийдвэрлэгдээгүй тохиолдолд газар эзэмшүүлж ашиглуулахыг

3.Аймгийн Засаг даргын 2003 оны 142 дугаар захирамжаар батлагдсан хил хязгаарт гэр хашааны зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулахыг.